



## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН  
ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН  
АУДИТЫН КОД: **БНА-2020/06/ГА**

**АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛААС  
ХУДАЛДАН АВСАН ЦААШИД АШИГЛАХ  
БОЛОМЖТОЙ ХӨРӨНГҮҮДИЙГ ОРЛОГООР  
БҮРТГЭЭГҮЙ БАЙНА.**

---

**Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)

**Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цээням**

Утас: 70442424 цахим хуудас: [tseenyma@audit.gov.mn](mailto:tseenyma@audit.gov.mn)

**Ахлах аудитор Б.Должмаа**

Утас: 88119345 цахим хуудас: [doljmaab@audit.gov.mn](mailto:doljmaab@audit.gov.mn)

**Аудитор Б.Нарангэрэл**

Утас: 99009293 цахим хуудас: [narangerelb@audit.gov.mn](mailto:narangerelb@audit.gov.mn)

**Аудитор Н.Бүнчинсүрэн**

Утас: 99049866 цахим хуудас: [bunchinsurenn@audit.gov.mn](mailto:bunchinsurenn@audit.gov.mn)

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг

дараах хаягаар авна уу. Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/22

Номгон

Тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалаар батлагдсан "Эрх шилжүүлэх" тухай тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дүгээр зүйлийн 12.40 дахь заалтыг үндэслэн **ТУШААХ** нь:

Нэг. "Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

Хоёр. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор /Б.Должмаа/, аудитор Б.Нарангэрэл, Н.Бүнчинсүрэн нарт үүрэг болгосугай.

Гурав. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн Сонгуулийн хороо, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст тус тус хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /Б.Должмаа/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер /А.Цээням/-д тус тус даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

005010012

**АГУУЛГА**

<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>3</b>
<b>ХҮСНЭГТИЙН ТОВЬЁГ .....</b>	<b>3</b>
<b>АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ .....</b>	<b>3</b>
<b>ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....</b>	<b>5</b>
<b>БҮЛЭГ 1. СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС ИРҮҮЛСЭН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТУХАЙ ТАЙЛБАРЫН ДАГУУ БАТЛАГДСАН ЗАРДЛЫГ СУМЫН СОНГУУЛИЙН ХОРОО, ХЭСГИЙН ХОРООДОД ХУВААРИЛСАН БАЙНА. ....</b>	<b>6</b>
УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОХ АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНООС АВСАН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛД ҮНДЭСЛЭН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС БАТАЛЖ ХУВААРИЛЖЭЭ. ....	6
УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДАЛД БАТЛАГДСАН САНХҮҮЖИЛТИЙГ СОНГУУЛИЙН БОЛОН ХЭСГИЙН ХОРООДОД ХУВААРИЛАХДАА СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС ИРҮҮЛСЭН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛБАРЫГ МӨРДӨЖ АЖИЛЛАСАН БАЙНА.БА .....	7
ИНА .....	7
<b>БҮЛЭГ 2. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО, ЗАРИМ ХЭСГИЙН ХОРООД БАТЛАГДСАН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛААГҮЙ, ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ ХЭМНЭХ БОДЛОГЫГ БАРЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА. ....</b>	<b>9</b>
АНХАН ШАТНЫ БАРИМТГҮЙ ЗАРДЛЫГ ОЛГОЖ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 13 ДУГААР ЗҮЙЛИЙГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА. ....	9
УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОСОН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА. ....	13
<b>ДҮГНЭЛТ: .....</b>	<b>15</b>
<b>АУДИТААС ДЭВШҮҮЛЖ БҮЙ САНАЛ.....</b>	<b>16</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
УБЕГ	Улсын бүртгэлийн Ерөнхий газар
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал харуцлагатай компани

**Хүснэгтийн товьёг**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан зардал	8
Хүснэгт 2	Аймаг, сумдын хороодод хуваарилсан зардал	9
Хүснэгт 3	Баянхонгор аймгийн Сонгуулийн хорооны зардлын тайлан	10-11

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**

**Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу гүйцэтгэв.

**Аудитын зорилт**

Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гарган ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

**Аудитын хамарсан хүрээ**

Дээрх зорилтын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэв. Үүнд:

1. Аймаг, сумын ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах зардлыг холбогдох хууль, журмын дагуу хуваарилсан эсэх?
2. Аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулж, үнэн зөв тайлагнаж, хяналт тавьж ажилласан эсэх?

**Аудитын хязгаарлалт**

Аудитаар Баянхонгор аймгийн болон сумдын сонгуулийн хороо, хэсгийн хороод, аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийг хамруулан шалгав.

Аймгийн сонгуулийн хороонд СЕХ-ноос батлагдсаны дагуу хуваарилагдаж ирсэн зардлаас бусад зардал хамаарахгүй.

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 3000-3100, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Гүйцэтгэлийн аудит MNS6817:2020, Гүйцэтгэлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт боловсруулав.

**Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

**Аудитын арга зүй,  
шалгуур үзүүлэлт**

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай;
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль;
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер А.Цээням үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж ажиллав.

**Аудитын багийн  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

Тус аудитыг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ахлах аудитор Б.Должмаа, аудитор Б.Нарангэрэл хамтран гүйцэтгэхээр төлөвлөсөн байсан боловч аудитор Б.Нарангэрэл хүндэтгэх шалтгаан гарч чөлөө авсан тул аудитыг багт аудитор Н.Бүнчинсүрэнг томилж, 2020.11.05-ны өдөр аудитад оролцож, аудитыг хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2020.10.26-ний өдөр эхлүүлж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, 2020.11.13-ний өдөр ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар, аймгийн Сонгуулийн хороо, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэв.

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.07.31-ний өдрийн 47 дугаар тогтоолоор аймаг, сумын ИТХ-ын сонгуулийг аймгийн Сонгуулийн хороог аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Дашцэрэнгээр ахлуулж, 9 хүний бүрэлдэхүүнтэй томилжээ.

Аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Дашцэрэн ажлаас чөлөөлөгдсөн тул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2020.08.26-ны өдрийн 65 дугаар тогтоолоор сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж, аймгийн сонгуулийн хорооны даргаар гишүүнээр ажиллаж байсан аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга М.Өнөржаргалыг, түүний оронд аймгийн ЗДТГ-ын мэргэжилтнийг томилж Сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан байна.

Аймгийн сонгуулийн хорооны даргын 2020.08.27-ны өдрийн 01 дүгээр захирамжаар аймгийн Сонгуулийн хорооны нягтлан бодогчоор Г.Ганчимэг, архив, бичиг хэргийн ажилтнаар Ц.Бадамгарав нарыг томилж, аймгийн Сонгуулийн хороо нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2020.08.25-ны өдрийн А/34 дүгээр захирамжаар аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны зардлын хуваарийг баталсан бөгөөд аймгийн сонгуулийн хороо, сумын 20 хороо, 106 хэсгийн хорооны зардалд улсын төсвөөс Баянхонгор аймагт 532709.0 мянган төгрөгийг баталсныг аймгийн Төрийн сан дахь 100030022001 тоот дансаар дамжуулан 523127.8 мянган төгрөгийг зарцуулж, зардлын хэмнэлтийг улсын төсөвт журамд заасан хугацаанд төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн сонгуулиар Баянговь сумын 1-р баг, Бөмбөгөр сумын 4-р баг, Эрдэнэцогт сумын 5-р баг, Өлзийт сумын 6-р баг, Жаргалант сумын 1-р багт саналын тоо тэнцсэн тул дахин сонгуулийг явуулж, сонгуулийг зохион байгуулах зардалд 2020.10.21-ны өдөр СЕХ-ноос 7315.0 мянган төгрөг хуваарилж, гүйцэтгэлээр 6228.1 мянган төгрөгийг зарцуулж, 1086.9 мянган төгрөгийг хэмнэж, хэмнэлтийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Аймгийн Сонгуулийн хороо 11, 20 сумын сонгуулийн хороонд 104, 106 хэсгийн хороонд 768, аймгийн Сонгуулийн хорооны дэргэдэх мэдээлэл технологийн багт 5, улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан 114, сумдын хэсгийн хороодод мэдээлэл технологийн даамал 106, нөөц даамал 21, хамгаалалтын ажилтан 106 ажилласан байна.

Орон нутгийн ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой байгууллагын дансаар зардал хуваарилагдаж ирснийг аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Эрүүл мэндийн газрын нягтлан бодогчоос тодруулахад Улсын бүртгэлийн хэлтсээс бусад байгууллагад орон нутгийн ээлжит сонгууль зохион байгуулах зардал хуваарилагдаагүй байна.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн ээлжит сонгууль зохион байгуулах зардалд УБЕГ-аас 72458.5 мянган төгрөгийн төсөв хуваарилж зарцуулсан тул гүйцэтгэлийн аудитаар зардлын зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгав.

## **БҮЛЭГ 1. СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС ИРҮҮЛСЭН ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТУХАЙ ТАЙЛБАРЫН ДАГУУ БАТЛАГДСАН ЗАРДЛЫГ СУМЫН СОНГУУЛИЙН ХОРОО, ХЭСГИЙН ХОРООДОД ХУВААРИЛСАН БАЙНА.**

УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОХ АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫГ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРООНООС АВСАН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛД ҮНДЭСЛЭН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС БАТАЛЖ ХУВААРИЛЖЭЭ.

- 1.1. Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардлын хэрэгцээ, шаардлагыг нутаг дэвсгэрийн сонгогчийн тоо, сонгууль зохион байгуулахад оролцох ажилтны тоо, сум болон хэсгийн хорооны тоо тэдгээрийн байршил хоорондох зай зэрэг шаардлагатай мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсний үндсэн дээр сонгууль зохион байгуулах зардлын төсвийг эдийн засгийн ангиллын дагуу баталж хуваарилсан байна.
- 1.2. Зардлын хэрэгцээ шаардлагыг тооцохдоо маягт хэвлэх, үнэмлэх хэвлэх, сургалт, бичиг хэрэг, шуудан холбооны зардал, хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардлыг тогтмол байхаар, зардлын хэмжээг тогтоож өгсөн бол хорооны унааны зардлыг газар нутгийн байршил, сонгогчийн тоо гэсэн үзүүлэлтүүдийг харгалзсан байна.
- 1.3. Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2020.08.25-ны өдрийн А/34 дүгээр захирамжаар аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах аймгийн сонгуулийн хороо, 20 сумын сонгуулийн хороо, 106 хэсгийн хорооны зардалд улсын төсвөөс Баянхонгор аймагт 532709.0 мянган төгрөгийг баталжээ.
- 1.4. Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой зардалд Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албанаас 5 удаагийн албан бичгийн дагуу нийт 532709.0 мянган төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс хуваарилсан байна.
- 1.5. СЕХ-ны Ажлын албанаас 2020.10.21-ний өдрийн 3/477 дугаар албан бичгээр хуваарилсан 8015.0 мянган төгрөгийн 7315.0 мянган төгрөг нь нэмэлт санал хураалт явуулах зардал, 700.0 мянган төгрөг нь Баацагаан сумын хэсгийн хорооны тоог дутуу тооцсоны улмаас нэмж олгосон санхүүжилт байна.
- 1.6. Улсын төсвөөс аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардалд батлагдсан санхүүжилтийн 64 хувийг аймаг, сум, хэсгийн хороодод ажилласан ажилтнууд, мэдээлэл технологийн баг, даамлуудад олгосон урамшуулал, хоолны мөнгөнд, 10.3 хувийг унааны зардалд, 5.2 хувийг сонгуулийн баримт болон техник хэрэгслийг сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах, тээвэрлэх зардалд, 4.4 хувийг санал авах байр бэлтгэх, тохижуулах зардалд олгосон нь хамгийн өндөр хувийг эзэлсэн байна.

№	Зардлын төрөл	СЕХ-ны Ажлын албаны 2020.08.26 өдрийн 3/396 дугаар албан бичиг	СЕХ-ны Ажлын албаны 2020.09.14 өдрийн 3/430 дугаар албан бичиг	СЕХ-ны Ажлын албаны 2020.09.28 өдрийн 3/450 дугаар албан бичиг	СЕХ-ны Ажлын албаны 2020.10.07 өдрийн 3/465 дугаар албан бичиг	СЕХ-ны Ажлын албаны 2020.10.21 өдрийн 3/477 дугаар албан бичиг	ДҮН
1	Сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах, тээвэрлэх зардал		22,534.0			5,046.0	27,580.0
2	Тогтоол, протокол, албан бичгийн хэвлэмэл хуудас, маягт хэвлүүлэх зардал	300.0					300.0
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал		3,710.0				3,710.0
4	Дүн мэдээ дамжуулах зардал						-
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал		23,320.0				23,320.0
6	Сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал	19,584.0					18,850.5
7	Мэдээллийн технологийн багийн зардал		650.0				650.0
8	Сонгуулийн байгууллагын ажилтан сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал				297,060.0	1,490.0	298,550.0
9	Мэдээллийн технологийн багийн гишүүн, хэсгийн хорооны даамлуудын урамшуулал, хоолны мөнгө				43,760.0		43,760.0
10	Бичиг хэргийн зардал	3,800.0	8,480.0				13,013.5
11	Шуудан, холбооны зардал	4,000.0	10,600.0				14,600.0
12	Унааны зардал	1,750.0	54,200.0				54,837.0
13	Унааны зардал /Туршилтийн болон санал авах өдрийн мэдээ дамжуулах/		4,180.0			275.0	4,455.0
14	Албан томилолтын зардал		5,528.0	2,522.0		1,054.0	10,217.0
15	Үнэмлэх хэвлэх зардал	2,900.0					2,900.0
16	Сурталчилгааны зардал		8,000.0				8,000.0
17	Болзошгүй зардал			4,000.0	3,816.0	150.0	7,966.0
18	Бусад зардал						-
	ДҮН	32,334.0	141,202.0	6,522.0	344,636.0	8,015.0	532,709.0

Эх сурвалж: СЕХ-ний Ажлын албанаас ирүүлсэн албан бичгүүд

УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДАЛД БАТЛАГДСАН САНХҮҮЖИЛТИЙГ СОНГУУЛИЙН БОЛОН ХЭСГИЙН ХОРООДОД ХУВААРИЛАХДАА СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНООС ИРҮҮЛСЭН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛБАРЫГ МӨРДӨЖ АЖИЛЛАСАН БАЙНА.

1.7. СЕХ-ны Ажлын албанаас батлагдсан санхүүжилтийг хэрхэн зарцуулах талаар "Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбар"-ыг тухай бүр ирүүлж, тус тайлбарыг үндэслэн аймаг, сум, хэсгийн хороодод хуваарилалтыг хийх, хуваарилсан төсвийг зүйл анги хооронд шилжүүлэхгүй байх, зардлыг өөр зориулалтаар ашиглахгүй байхыг чиглэл болгосон байна.

1.8. Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албанаас ирүүлсэн төсвийн зарцуулалтын тайлбарыг үндэслэн аймгийн Сонгуулийн хороо сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодод батлагдсан төсвийг үндэслэлтэй хуваарилж, аймгийн Сонгуулийн хорооны даргын захирамжаар сонгуулийн зардлыг зарцуулах тайлбарыг хүргүүлж ажилласан байна.

1.9. Аймгийн Сонгуулийн хороо улсын төсвөөс хуваарилагдсан нийт санхүүжилтийн 18.1 хувийг аймгийн Сонгуулийн хорооны зардалд, 81.9 хувийг 20 сумын Сонгуулийн хороо, 106 хэсгийн хорооны зардалд зардалд хуваарилжээ.

Хүснэгт 2. Аймаг, сумдын хороодод хуваарилсан зардал

/мян.төг/

№	Зардлын төрөл	Нийт зардал	Үүнээс	
			Аймгийн Сонгуулийн хороо	Сумдын хороо
1	Сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах, тээвэрлэх зардал	27,580.0	27,580.0	-
2	Тогтоол, протокол, албан бичгийн хэвлэмэл хуудас, маягт хэвлүүлэх зардал	300.0	300.0	-
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	3,710.0	-	3,710.0
4	Дүн мэдээ дамжуулах зардал	-	-	-
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	23,320.0	2,120.0	21,200.0
6	Сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал	18,850.5	18,850.5	-
7	Мэдээллийн технологийн багийн зардал	650.0	650.0	-
8	Сонгуулийн байгууллагын ажилтан сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	298,550.0	5,790.0	292,760.0
9	Мэдээллийн технологийн багийн гишүүн, хэсгийн хорооны даамлуудын урамшуулал, хоолны мөнгө	43,760.0	1,850.0	41,910.0
10	Бичиг хэргийн зардал	13,013.5	1,533.5	11,480.0
11	Шуудан, холбооны зардал	14,600.0	1,000.0	13,600.0
12	Унааны зардал	54,837.0	10,972.0	43,865.0
13	Унааны зардал /Туршилтын болон санал авах өдрийн мэдээ дамжуулах/	4,455.0	275.0	4,180.0
14	Албан томилолтын зардал	10,217.0	10,217.0	-
15	Үнэмлэх хэвлэх зардал	2,900.0	2,900.0	-
16	Сурталчилгааны зардал	8,000.0	8,000.0	-
17	Болзошгүй зардал	7,966.0	4,150.0	3,816.0
18	Бусад зардал	-	-	-
	<b>ДҮН</b>	<b>532,709.0</b>	<b>96,188.0</b>	<b>436,521.0</b>

Эх сурвалж: Аймгийн Сонгуулийн хорооны тайлан, аудитаар хийсэн тулгалт

1.10. Сонгуулийн ерөнхий хорооны 2020.09.02-ний өдрийн 281 дүгээр тогтоолоор аймаг, дүүргийн сонгуулийн хорооны дэргэд ажиллах мэдээллийн технологийн багийн бүрэлдэхүүнийг баталсан ба Баянхонгор аймагт ажиллах багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, ахлагчаар аймгийн ЗДТГ-ын ахлах мэргэжилтэн Б.Наранцэцэгийг томилж, батлагдсан зардлыг бүрэн хуваарилж, олгосон байна.

1.11. Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн дүнгээр Баянговь сумын 1-р баг, Бөмбөгөр сумын 4-р баг, Эрдэнэцогт сумын 5-р баг, Өлзийт сумын 6-р баг, Жаргалант сумын 1-р багт саналын тоо тэнцсэн тул Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1<sup>1</sup> дэх заалтын дагуу нэмэлт санал хураалтыг зохион байгуулсан байна.

1.12. Аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн нэмэлт санал хураалтыг зохион байгуулах зардалд СЕХ-ны Ажлын албаны 2020.10.21-ний өдрийн 3/477 дугаар албан бичгээр 7315.0 мянган төгрөг хуваарилсан ба аймгийн Сонгуулийн хорооны дарга

<sup>1</sup> Хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийн саналын тоо тэнцсэн бол адил санал авсан нэр дэвшигчдийн дунд нэмэлт санал хураалт явуулна.

2020.10.22-ны өдөр 06 дугаар захирамж гарган зардлыг хуваарилсан ба нийт зардлын 68.9 хувийг саналын хуудас, ИРС төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардалд хуваарилсан байна.

## БҮЛЭГ 2. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО, ЗАРИМ ХЭСГИЙН ХОРООД БАТЛАГДСАН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛААГҮЙ, ТӨСВИЙН ХӨРӨНГИЙГ ХЭМНЭХ БОДЛОГЫГ БАРЬЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

АНХАН ШАТНЫ БАРИМТГҮЙ ЗАРДЛЫГ ОЛГОЖ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 13 ДУГААР ЗҮЙЛИЙГ МӨРДӨЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

1.13. Сонгуулийн Ерөнхий хорооноос Баянхонгор аймгийн Сонгуулийн хороонд хуваарилсан 532709.0 мянган төгрөгийн санхүүжилтээс гүйцэтгэлээр 523127.7 мянган төгрөгийг олгож, зардлыг 9581.3 мянган төгрөгөөр хэмнэж, хэмнэлтийг улсын төсөвт төвлөрүүлж, СЕХ-ны 2016.03.02-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.3<sup>2</sup>-т заасныг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Баянхонгор аймгийн Сонгуулийн хорооны зардлын тайлан /мян.төг/

№	Зардлын төрөл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт/Хэмнэлт	Хувь
1	Сонгуулийн бичиг баримт болон техник хэрэгслийг сум, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах, тээвэрлэх зардал	27580.0	26643.0	937.0	5.1
2	Тогтоол, протокол, албан бичгийн хэвлэмэл хуудас, маягт хэвлүүлэх зардал	300.0	300.0	0.0	0.1
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	3710.0	3709.9	0.1	0.7
4	Дүн мэдээ дамжуулах зардал	0.0		0.0	-
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	23320.0	23320.0	0.0	4.5
6	Сонгуулийн байгууллагын ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, нөөц даамлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал	18850.5	18601.5	249.0	3.6
7	Мэдээллийн технологийн багийн зардал	650.0	650.0	0.0	0.1
8	Сонгуулийн байгууллагын ажилтан сонгуулийн байгууллагад ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	298550.0	298460.0	90.0	57.1
9	Мэдээллийн технологийн багийн гишүүн, хэсгийн хорооны даамлуудын урамшуулал, хоолны мөнгө	43760.0	43760.0	0.0	8.4
10	Бичиг хэргийн зардал	13013.5	13014.6	-1.1	2.5
11	Шуудан, холбооны зардал	14600.0	14080.0	520.0	2.7
12	Унааны зардал	54837.0	48865.1	5971.9	9.3
13	Унааны зардал /Туршилтын болон санал авах өдрийн мэдээ дамжуулах/	4455.0	4346.1	108.9	0.8
14	Албан томилолтын зардал	10217.0	9839.0	378.0	1.9
15	Үнэмлэх хэвлэх зардал	2900.0	2646.5	253.5	0.5
16	Сурталчилгааны зардал	8000.0	8000.0	0.0	1.5
17	Болзошгүй зардал	7966.0	6892.0	1074.0	1.3
18	Бусад зардал	0.0		0.0	-
	<b>ДҮН</b>	<b>532709</b>	<b>523127.7</b>	<b>9581.3</b>	<b>100</b>

Эх сурвалж: Аймгийн Сонгуулийн хорооны тайлан, аудитаар хийсэн тулгалт

<sup>2</sup> Сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийн зардлын үлдэгдлийг Сонгуулийн Ерөнхий Хорооны дансанд эргүүлэн төвлөрүүлнэ.

1.14. Аймаг, сумдын сонгуулийн хороодын зардлын тайланг төрийн сангийн дансны гүйлгээнээс баримтруу тулган шалгахад анхан шатны баримтгүйгээр зардал гаргасан, албан хаагчдад олгосон хоолны мөнгөнөөс хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй, жолоочийн замын хуудас байхгүй, кассаар олгосон бэлэн мөнгөний зардлын тайланг гаргаагүй зэрэг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4<sup>3</sup>, 13.6<sup>4</sup>, 13.7<sup>5</sup> дахь заалтыг зөрчсөн дараахь зөрчлүүд илэрлээ.

#### **Аудитын илрүүлэлт**

1. Аймгийн Сонгуулийн хорооны шуудан холбооны батлагдсан зардлаас 2020.09.02, 2020.10.13-ны өдөр аймгийн Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт тус бүр 100.0 мянга, хорооны 7 гишүүнд 280.0 мянга, мэдээлэл технологийн багийн 5 гишүүнд 100.0 мянга, нийт 580.0 мянган төгрөгийн холбооны зардлыг анхан шатны баримтгүй олгосон;
2. Аймгийн Сонгуулийн хорооны гишүүн О.Эрдэнэ-Оюун, Б.Наранцэцэг нарт орон нутгийн сонгуулийн хугацаанд ажиллах унааны зардалд анхан шатны баримтгүй тус бүр 100.0 мянган төгрөг олгосон;
3. Өлзийт сумын хэсгийн хорооны даамал Ч.Батдоржийн санал тоолох төхөөрөмжийг аймгийн Сонгуулийн хороонд хүлээлгэн өгсөн томилолтын 50.0 мянган төгрөгийг олгохдоо тус сумын хэсгийн хорооны нөөц даамал Б.Баасанжаргалын дансанд шилжүүлсэн;
4. Батлагдсан зардлаас худалдан авсан шатахууны талоноос 2020.10.13-ны өдөр хэв журам, харуул, тагнуул гэсэн утгаар тус бүр 250.0 мянга, нийт 500.0 мянган төгрөгийн шатахууны талон олгосон атлаа замын хуудас байхгүй зөрчил илэрсэнд аймгийн Сонгуулийн хороонд нийт 1330.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, аудитын явцад барагдуулав.
5. Баянбулаг сумын 3-4 дүгээр хэсгийн хороонд олгосон унааны зардлаас 17.5 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй, замын тооцооны хуудас бичилгүй зарцуулсан;
6. Баян-Өндөр сумын унааны зардлыг анхан шатны баримттай нь тулган шалгахад 7-2 дугаар хэсгийн хорооны гишүүнд олгосон 89.8 мянган төгрөгийн унааны зардлын жолоочийн тооцооны хуудас, шаардах хуудас байхгүй;
7. Богд сумын сонгуулийн 9-4-р хэсгийн хорооны шатахууны тайлангаар нийт 526.3 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан бөгөөд замын хуудастай тулган баталгаажуулахад 22.0 мянган төгрөгийн шатахууныг замын хуудасгүйгээр зарцуулсан;
8. Шинэжинст сумын 19-2 хэсгийн хорооны унааны зардалд 2020.10.12-ны өдөр 375.0 мянган төгрөг олгосон ба анхан шатны баримтыг тайланд хавсаргаагүй;
9. Шинэжинст сумын 19-3 дугаар хэсгийн хорооны унааны зардалд 2020.10.15-ны өдөр 300.0 мянган төгрөг олгосон ба шатахуун авсан анхан шатны баримтыг тулган шалгахад 265.0 мянган төгрөгийн шатахуун авч, 35.0 мянган төгрөгийн анхан шатны баримт байхгүй;
10. Шинэжинст сумын 19-3 дугаар хэсгийн хорооны унааны зардлын 265.0 мянган төгрөгийн шатахууны жолоочийн зам явсан хуудсыг стандарт бус маягтаар бөглөж, спидометрийн заалт бичиж тэмдэглээгүй;
11. Сонгуулийн өдөр санал авах байранд нэмэлтээр ажилласан эрүүл мэнд, онцгой байдлын ажилтнуудад Шинэжинст сумын хороо 144.0 мянга, Баянцагаан сум 180.0 мянган төгрөгийн хоолны мөнгийг олгохдоо Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21.1<sup>6</sup> дэх заалтыг зөрчиж, хоолны мөнгөнөөс хувь хүний орлогын албан татварыг суутган тооцоогүй;
12. Баянцагаан сумын Сонгуулийн хороо 2020.09.25-ний өдөр 300.0 мянга, 2020.10.08-ны өдөр 4393.8 мянган төгрөгийг кассаар дамжуулан олгож зарцуулсан байхад кассын тайланг бэлтгэж гаргаагүй;
13. Сумдын хэсгийн хорооны шуудан холбооны зардалд олгосон 100.0 мянган төгрөгийн зардлыг сумдын хэсгийн хороод бүх гишүүддээ жигд хуваарилж олгосон байхад

<sup>3</sup> Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

<sup>4</sup> Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

<sup>5</sup> Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

<sup>6</sup> Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна.

- Баянцагаан сумын хэсгийн хороодын дарга нар 60.0-65.0 мянган төгрөгийн зардал авч, гишүүдэд 5.0 мянган төгрөгийн зардлыг олгож харьцангуй хуваарилсан ба анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, шуудан холбооны зардлаас DDISH-ийн төлбөрт 9.0 мянган төгрөгийг төлсөн;*
14. *Аймаг, нийслэл, сум дүүргийн 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад корновируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор санал авах байрны ариутгал халдваргүйжүүлэлт гүйцэтгэх албан хаагчдыг Хүрээмарал сумын Засаг даргын 2020.10.14-ны өдрийн А/84 дугаар захирамжаар томилж, хоолны зардалд 180.0 мянган төгрөг олгохоор батлагдсан бөгөөд тус мөнгөнөөс хувь хүний орлогын албан татварт 18.0 мянган төгрөгийг суутгаж, 162.0 мянган төгрөгийг олгохоор байхад хэсгийн хорооны дарга нарын дансаар дамжуулан олгосон;*
  15. *Баянговь сумын сонгуулийн хорооны шатахууны тайланг замын хуудастай тулган баталгаажуулахад замын хуудаст явсан километр, спидометрийн заалт, бензиний норм, зарсан шатахуун зэргийг буруу бичсэн бөгөөд замын хуудсыг үйл ажиллагаанд явсан суудлын автомашин тус бүрд нь хөтлөөгүй;*
  16. *Заг сумын сонгуулийн хорооны шатахууны тайланг замын хуудастай нь тулган баталгаажуулахад 16-1 хэсгийн хороонд олгосон 30.0 мянга, 16-2 хэсгийн хороонд олгосон 119.7 мянган төгрөгийн замын хуудас байхгүй зэрэг зөрчил илэрлээ.*

Холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллаагүй дээрх зөрчлүүдэд буруутай албан тушаалтнуудаар төлүүлэх төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

1.15. УИХ-ын болон аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуулийн зардалд улсын төсвөөс тухай бүр зардал батлагдаж, санал авах байр бэлтгэх, тохижуулах зардалд батлагдсан санхүүжилтээс төрийн далбаа, уртасгагч залгуур, ус буцалгагч, саналын бүхээг гэх мэт цаашид дараагийн сонгууль болон төсөвт байгууллагуудад хэрэглэх боломжтой хөрөнгийг худалдан авсан атлаа хөрөнгөд бүртгэж аваагүй байгаа нь төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулах бодлого баримтлаагүйтэй холбоотой байна.

УИХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийсэн аудитаар хөрөнгийн чанартай 2100.0 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод авахуулах албан шаардлага өгсөн байхад зөрчлийг давтан гаргасан байна.

Аудитаар аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуулийн санал авах байр бэлтгэх, тохижуулах зардлаас хэсгийн хорооны худалдан авсан хөрөнгийг тулгах горим сорилыг хэрэгжүүлэхэд цаашид ашиглагдах 8830.5 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг 20 сумын ИТХ-ын хөрөнгөд бүртгэж, дараагийн үйл ажиллагаанд ашиглаж байх албан шаардлагыг аймгийн Сонгуулийн хороонд өгч, Сонгуулийн Ерөнхий хороонд санал авах байр бэлтгэх, тохижуулах зардлыг хэмнэх боломжтой талаарх саналыг хүргүүлэв.

1.16. Аудитын явцад аймаг, сумын ИТХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулах зардалд бусад төсөвт байгууллагуудад зардал олгосон эсэхийг аймгийн Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтсээс тодруулсан ба аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс бусад байгууллагад сонгууль зохион байгуулахтай холбоотой зардал гараагүй байна.

1.17. Харин аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст Улсын бүртгэлийн Ерөнхий газрын /цаашид УБЕГ гэх/ даргын 2020.09.02-ний өдрийн А/1304 дүгээр тушаалаар аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулах зардалд 70778.5 мянган төгрөг хуваарилсан ба тус санхүүжилтийг хэлстийн нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж зарцуулсан байна.

СЕХ-ны 2020.09.02-ний өдрийн 285 дугаар тогтоолын хавсралтаар Баянхонгор аймгийн 4 суманд 4 хэсэг шинээр байгуулах шийдвэр гарч, түүний зардалд 1680.0 мянган төгрөгийг хуваарилснаар, орон нутгийн 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах зардалд нийт 72458.5 мянган төгрөгийг олгосон байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосн дээрх зардлын гүйцэтгэлийг 2020.11.05-ны өдөр анхан шатны баримттай тулган шалгахад гүйцэтгэлээр 63660.3 мянган төгрөгийг олгож, 8798.2 мянган төгрөг үлдэгдлээр байснаас 2060.0 мянган төгрөг нь Улаанбаатар хотод тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн зардалд олгохоор, 5625.0 мянган төгрөг нь УБЕГ-ын даргын 2020.10.23-ний өдрийн А/1424 дүгээр тушаалаар сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд ажлын бус цагаар ажилласан 20 албан хаагчид олгох мөнгөн урамшуулалд олгохоор хүлээгдэж байгаа зардлын гүйцэтгэл байгаа ба харин 1113.2 мянган төгрөг нь бусад зардлын хэмнэлт байна.

1.18. УБЕГ-аас хуваарилсан бичиг хэргийн зардлаас 742.2 мянга, томилолт унааны зардлаас 130.4 мянга, сургалтын зардлаас 240.6 мянга, нийт 1113.2 мянган төгрөгийг хэмнэсэн атлаа төсөвт буцаан төвлөрүүлээгүй зөрчил илэрсэн тул орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

1.19. Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулгах горим сорилыг хэрэгжүүлэхэд дараах зөрчил илэрлээ.

#### Аудитын илрүүлэлт

1. "Шунхлай трейдинг" ХХК-аас 2020.10.01-ны өдөр 1260.0 мянган төгрөгийн шатахуун авч, сонгогчийн нэрийн жагсаалтыг 3 суудлын автомашинаар 19 суманд хүргэсэн, 2020.10.29-ны өдөр 443.6 мянган төгрөгийн шатахуун авч, Шаргалжуут тосгоны 8 дугаар багт ажилласан итгэмжлэгдсэн ажилтны унааны зардалд 15.0 мянга, Галуут, Богд сумд сонгуулийн өдөр буюу 2020.10.15-ны өдөр гэмтэл гарч, 2 шуурхай баг очиж ажиллахад 428.6 мянган төгрөг олгосон гэх боловч анхан шатны баримт, замын хуудсыг хавсаргаагүй;
2. Орон нутгийн сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтны урамшуулалд 2020.10.30-ны өдөр Хаан банкаар 21546.0 мянга, Төрийн банкаар 18522.0 мянга, нийт 40068.0 мянган төгрөгийг сумын улсын бүртгэгчийн дансаар дамжуулан олгосон ба Баян-Өндөр, Галуут, Жинст, Баацагаан, Бууцагаан сумаас бусад сум ажилтнуудад олгосон 29484.0 мянган төгрөгийн жагсаалтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст ирүүлээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчсөн дээрх зөрчлүүдэд хугацаатай албан шаардлага өгч ажиллав.

1.20. Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын гэр бүлийн хүн Ж.Ганболдтой, хэлтсийн нягтлан бодогч Г.Бат-Очир Улаанбаатар хотоос ачаа тээвэрлэх 2060.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан байгаа нь Нийтийн албанд нийтийн болон

хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Иймд дээрх үйлдлийг давтан гаргахгүй байх талаар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргад зөвлөв.

## УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОСОН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙНА.

1.21. Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.4<sup>7</sup>, 4.6<sup>8</sup> дахь заалтын дагуу аймгийн Сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй байгаа ба аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч нь сумдын сонгуулийн зардлын тайлан, анхан шатны баримтыг аймгаас хуваарилсан зардлын нэгтгэлтэй тулган зөрүүтэй гаргасан тайланг тухай бүр нь засуулах зэргээр хүлээж авахдаа хяналт хэрэгжүүлсэн гэх тайлбарыг өгсөн ч аудитаар зарим сумдын тайлан анхан шатны баримт дутуу, хуваарилсан зардлыг хооронд нь гүйлгэн зарцуулсан байгаа нь хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

1.22. Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3.2<sup>9</sup>-т заасныг зөрчиж Баянлиг сумын Сонгуулийн хорооны бичиг хэргийн зардалд 150.0 мянган төгрөг хуваарилсан байхад гүйцэтгэлээр 178.5 мянган төгрөг зарцуулж, батлагдсан зардлыг 28.5 мянган төгрөгөөр хэтрүүлсэн ба хэсгийн хороодод хуваарилсан зардлаас 19.2 мянган төгрөгийг дутуу олгож, унааны зардлаас 9.3 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

1.23. Сумдын сонгуулийн хороод нь тайлан ирүүлэхдээ тайлангийн товч танилцуулга, тодруулгыг ирүүлээгүй байхад аймгийн Сонгуулийн хорооны нягтлан бодогч хүлээж авсан байгаа нь Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4.3.2<sup>10</sup> дахь заалтыг зөрчсөн байна.

1.24. Иймд аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон сумдын сонгуулийн хороодын зардлын тайланг хүлээж авахдаа шат

<sup>7</sup> Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороо болон төв комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина.

<sup>8</sup> Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сум, дүүргийн сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авч, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны санхүүгийн анхан шатны баримтын хамт архивын нэгж болгон аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын архивд албан ёсоор хүлээлгэн өгнө

<sup>9</sup> Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ

<sup>10</sup> Тайлангийн товч танилцуулга, тодруулга

шатны хяналтыг бүрэн хэрэгжүүлж зөрчлийг давтан гаргахгүй байхыг аймгийн Сонгуулийн хорооны даргад зөвлөв.

Монгол Улсын Засгийн газраас гаргасан цар тахалтай холбоотой шийдвэрийн дагуу аймгийн Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нарт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төслийг цахим хаягаар явуулж, саналыг авахад саналгүй гэсэн хариуг цахимаар ирүүлсэн болно.

Аудитаар нийт 50401.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2648.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 45663.7 мянган төгрөгийн албан шаардлага өгч, 2088.5 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөв.

## ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн зардалд улсын төсвөөс олгосон 532709.0 мянган төгрөгийн зардлыг сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодод хуваарилахдаа Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн төсвийн зарцуулалтын тухай тайлбарыг баримталж ажилласан байна.
2. Аймгийн Сонгуулийн хороо, зарим хэсгийн хороод батлагдсан зардлаас анхан шатны баримтгүй 1453.3 мянган төгрөгийг олгож, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй байна.
3. Аймаг, сумын ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах зардлаас худалдан авсан дараагийн сонгууль болон төсөвт байгууллагуудад цаашид ашиглагдах боломжтой 8830.5 мянган төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг хөрөнгөд бүртгэж, төсвийн хөрөнгийг хэмнэх бодлогыг барьж ажиллаагүй байна.
4. Анхан шатны баримтгүй гүйлгээ байхгүй, баримтын бүрдэл дутуу байхад аймгийн Сонгуулийн хороо сумдын сонгуулийн хорооны зардлын зарцуулалтад хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж, Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## АУДИТААС ДЭВШҮҮЛЖ БҮЙ САНАЛ

Аудитын дүнд үндэслэн дараах саналыг Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлж байна. Үүнд:

